



## АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:**

Баян-Өлгий аймгийн  
Аудитын газар

Дарга, Тэргүүлэх аудитор  
М.Хуанган  
Утас: 70422954  
Цахим хаяг:

Аудитын менежер:  
Х.Женисбек  
Утас: 70422930  
Цахим хаяг:

Ахлах аудитор: М.Айнур  
Утас: 94159291  
Цахим хаяг:  
ainurmarkhava@yahoo.com

**Хаяг:** Баян-Өлгий аймгийн  
Аудитын газар

**Байршил:** Өлгий сум, 5-р баг,  
Аймгийн ЗДТГазрын байр, 1-р  
давхар  
**Цахим хуудас:** [www.audit.mn](http://www.audit.mn)

**2018 оны 2 дугаар сар**

### Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

## **АГУУЛГА**

---

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

### **Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:**

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2-т заасан аймаг дах Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /БӨА-2018/71/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 15-ноос 2 дугаар сарын 02-ны хооронд хийхээр төлөвлөж, Баян-Өлги аймаг дах Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Айнур хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2017 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанд буюу 2017 оны 1 дугаар сарын 25-нд Аймгийн Аудитын газарт ирүүлсэн.

Аймаг дах Төрийн аудитын газар аудитыг 2018 оны 2 дугаар сарын 20-ноос 2 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2 дугаар сарын 26-нд Нэгдсэн эмнэлгийн удирдлагад гардуулна.

### **Байгууллагын хууль, эрх зүйн орчин:**

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн

өмчийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

### **Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:**

“Эелдэг харилцаа, чанартай үйлчилгээ” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга нь Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2017 оны төсвийг аймгийн Эрүүл мэндийн сайдын төсвийн багцаас аймгийн төрийн сангаас олгосон байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

### **Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 10-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад тус эмнэлэг нь санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлаагүй боловч Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсвийн байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар аргачлал, нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүйг мөрдөж ажилласан байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “Санхүүгийн тооцоолох төв” ХХК-ны “Аколоус” санхүүгийн програмаар боловсруулан төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

#### **Дотоод хяналт:**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед 30 буюу “их” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

#### **Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:**

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Эрүүл мэндийн сайдын төсвийн багцаас аймгийн төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн төсвийн захирагч нь 2017 онд 6187,8 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулжээ. Санхүүжүүлэх эх үүсвэрийн хувьд 3636,4 сая төгрөгийг улсын төсвөөс, 2450,3 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 101,1 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэн зарцуулахаар тусгагджээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3636,4 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 2450,3 сая төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны орлогоос 101,1 сая төгрөг бүрдүүлэн нийтдээ 6187,8 сая төгрөгийн зарлага санхүүжилтээр ажиллажээ.

### **Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулинд заасны дагуу [shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn) вэб сайтанд байгууллагын 2017 оны батлагдсан төсвийн мэдээллийг оруулсан байна. 2017 онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитаар Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь мэдээлэлээ бүрэн оруулсан, зөрчил дутагдал гараагүй байна.

2017 оны 10-12 дугаар саруудын шилэн дансны мэдээллийг аудиторын зүгээс шалгаж Shilen dans-ман файлаар баримтжуулж, тайлантай хамт ажлын талбарт хавсаргав.

### **Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:**

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 5 чиглэлд 10 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 24 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. Үр дагаварыг тодорхойлвол: Аудитаар санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхээр алдаа зөрчил илрээгүй болно.

### **Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:**

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний санхүүжилт орлого, нэмэлт санхүүжилт, цалин, НДШ, ХХОАТ, түлш халаалт, шатахуун, хоол, эм, гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, нэг удаагийн тэтгэмж урамшуулал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

### **Тайлант оны онцлог гүйлгээний талаар тодруулбал:**

Тайлант онд Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2017 онд өндөр насны тэтгэвэрт 15 хүн гарсан байхад оронд нь 15 хүнийг ажилд авсны дээр, шинээр 8 хүнийг ажилд нэмж авсан байна.Өнгөрсөн оны өр болох 105,9 сая төгрөгийг тайлант онд барагдуулж ажилласан байна.

### **Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.Аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөх

материаллаг алдаа зөрчил илрээгүй боловч анхаарал татах дараах асуудал байна.Үүнд:

1.Аймгийн Нэгдсэн эмнэлгийн орон тооны хязгаарыг Эрүүл мэндийн яамнаас 328 хүнээр баталсан ба гүйцэтгэлээр 408 хүн ажиллуулж, орон тооны хязгаарыг 80 хүнээр хэтрүүлэн ажиллуулжээ. 2017 онд өндөр насны тэтгэвэрт 15 хүний оронд 15 хүнийг, шинээр 8 хүнийг ажилд авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.3-т “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, Улсын Их Хурлын 2016 оны 69 дүгээр тогтоолын 3.1-д "төрийн албан хаагчийн тоог 2017 оны төсвийн жилд нэмэгдүүлэхгүй байх", Улсын Их Хурлын 29 дүгээр тогтоолын 1.6-д "эрүүл мэнд, боловсрол, цагдаа, онцгой байдлын салбараас 2017-2019 онд өндөр насны тэтгэвэрт гарах 2 төрийн албан хаагч тутамд 1 албан хаагчийг нөхөн томилох..." гэсэн залтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

2.Сахилгын шийтгэл ногдуулсан сувилагч Х.Меруерт, ня-бо Ш.Азинегүл нарт сахилгын шийтгэлийн хугацаа дуусаагүй байхад Засгийн газраас олгосон сахилга хариуцлага, ажлын үр дүнгийн урамшууллын мөнгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.3 “төсвийн гүйцэтгэлийн хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж тайлагнах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.4-т “Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно”, Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 52 дугаар “Урамшуулал олгох тухай” тэмдэглэлд “УИХ-ын 2017 оны 67 дугаар тогтоолын дагуу төрийн албан хаагчид 300000 төгрөгийн урамшуулал олгох тухай асуудлыг хэлэлцээд сахилгын шийтгэл хүлээсэн бөгөөд сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа нь дуусаагүй байгаа албан хаагчаас бусад төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох арга хэмжээ авахыг төсвийн шууд захиргч нарт даалгав” гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Урамшууллын мөнгийг нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

3.Эрүүл мэндийн даатгалын сангаас оны эцэст шилжүүлсэн 30,9 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт нь дансны нэр андуурч үндсэн дансанд орж, оны эцсийн гүйлгээ хаах хугацаанд тулсан учир аймгийн Төрийн сангийн зөвшөөрлөөр арилжааны банкин дахь дансаар дамжуулан бэлнээр авч зарцуулжээ.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 6.2-т "жилийн батлагдсан төсвийн дүн 1.000.000.000 төгрөгөөс дээш жижиг мөнгөн сан 1500.000-3000.000" гэснийг, 6.3-т "төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа үйлчилгээний болон харилцах дансгүй этгээлийн төлбөрийг бэлэн мөнгөөр

гүйцэтгэх ба бараа үйлчилгээний төлбөрийн нийт дүн 300.0 мянган төгрөг, тээвэр шатахууны хэмжээ 500.0 мянган төгрөгөөс хэтрэхгүй байна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

### **Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:**

Байхгүй.

### **Анхаарал татахуйц бусад чухал асуудал:**

Батлагдсан орон тоог хэтрүүлэн ажиллуулсны дээр тайлант онд нийтдээ 23 хүнийг ажилд авсан нь УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоол, УИХ-ын 2016 оны 69 дүгээр тогтоолын зөрчсөн асуудлыг төрийн аудитын байгууллага анхааралдаа авч, дараагийн аудитаар заавал үзэх шаардлагатай байна.

### **Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:**

Дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар орон тооны асуудлыг тодруулан үзэх шаардлагатай.

### **Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн асуудлыг алдаа зөрчлийн нэгтгэл маягтаар нэгтгэж харуулав.

### **Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:**

Өмнөх онд зөвлөмж өгөгдөөгүй байна.

### **Зөвлөмж**

Тайлант онд зөвлөмж өгөгдөөгүй байгаа болно.

### **Зөрчилгүй санал дүгнэлт**

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 8 хуудас, хавсралтууд хуудсыг тус тус хавсаргав.



АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН  
ОГНОО:2018.02.24

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК  
ОГНОО:2018.02.24

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

М.АЙНУР ОГНОО:2018.02.24